



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын  
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/9/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14

### **Товчилсон үгийн жагсаалт**

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

“ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР” ОНӨААТҮГ-  
ЫН ДАРГА З.ЭРДЭНЭБАТ ТАНАА

2025.02.14 № 162

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүү тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна. □

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг □ онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1,096,686.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн албан тушаалын цалин, хөлсний доод нийтлэг жишгийг батлах тухай” 52 дугаар тогтоолыг үндэслэн албан

хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 2,307,704.4 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 13.4 хувиар өссөн байна.

### **Бусад асуудал**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 94 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ш.МӨНХБАЯР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН


### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Д/д	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,777,991.15	822,556,014.67
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.6	Бараа материал	789,318,994.28	751,963,691.78
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>793,096,985.43</b>	<b>1,574,519,706.45</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	20,649,213,677.61	28,328,002,043.36
1.2.2	Биет бус хөрөнгө	3,052,226,560.16	2,646,749,830.68
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>23,701,440,237.77</b>	<b>30,974,751,874.04</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,494,537,223.20</b>	<b>32,549,271,580.49</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.9	Богино хугацаат бусад өр төлбөр	177,198,935.69	-
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>177,198,935.69</b>	<b>-</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	28,580,981,981.47	39,275,814,113.15
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(4,263,643,693.96)	(6,726,542,532.66)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>24,317,338,287.51</b>	<b>32,549,271,580.49</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>24,494,537,223.20</b>	<b>32,549,271,580.49</b>



## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Д/д	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,557,142,873.36	6,085,807,809.38
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг ( алдагдал)	4,557,142,873.36	6,085,807,809.38
4	Түрээсийн орлого		
8	Бусад орлого	1,414,328,506.87	784,828,366.67
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,937,925,891.22	9,038,304,778.34
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(21,942,548.32)	(295,230,236.41)
17	Бусад ашиг ( алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)	(2,988,397,059.31)	(2,462,898,838.70)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,988,397,059.31)	(2,462,898,838.70)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	(2,988,397,059.31)	(2,462,898,838.70)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(2,988,397,059.31)	(2,462,898,838.70)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		




2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>21,022,748,703.85</b>		-	<b>(1,275,246,634.65)</b>	<b>19,747,502,069.20</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>21,022,748,703.85</b>		-	<b>(1,275,246,634.65)</b>	<b>19,747,502,069.20</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,988,397,059.31)	(2,988,397,059.31)
Өмчид гарсан өөрчлөлт	7,558,233,277.62				7,558,233,277.62
Бусад дэлгэрэнгүй орлого					-
<b>2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>28,580,981,981.47</b>	-	-	<b>(4,263,643,693.96)</b>	<b>24,317,338,287.51</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	-	-	-	<b>24,317,338,287.51</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,462,922,838.64)	(2,462,922,838.64)
Өмчид гарсан өөрчлөлт	(28,580,981,981.47)		39,275,838,113.49		10,694,856,132.02
Бусад дэлгэрэнгүй орлого					-
<b>2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	-	-	<b>39,275,838,113.49</b>	<b>(2,462,922,838.64)</b>	<b>32,549,271,580.89</b>



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,875,549,348.23	6,870,636,176.05
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	4,160,280,000.00	5,064,090,200.00
	Бусад мөнгөн орлого	1,715,269,348.23	1,806,545,976.05
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,969,112,677.89	6,051,858,152.53
	Ажиллагчдад төлсөн	2,035,694,175.00	2,274,083,322.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	539,669,104.79	282,149,476.29
	Бараа материал худалдан авахад төлсөн	-	-
	Ашиглалтын зардалд төлсөн	429,947,703.95	859,671,688.08
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	596,959,192.92	547,767,666.00
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	-	-
	Даатгалын төлбөрт төлсөн	2,440,000.00	9,205,080.00
	Бусад мөнгөн зарлага	2,364,402,501.23	2,078,980,920.16
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(93,563,329.66)</b>	<b>818,778,023.52</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(93,563,329.66)</b>	<b>818,778,023.52</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>97,341,320.81</b>	<b>3,777,991.15</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,777,991.15</b>	<b>822,556,014.67</b>



2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>						
<b>Нийт орлого</b>	м/төг	5,971,471,380.23	<b>5,780,192,008.00</b>	<b>6,870,636,176.05</b>	<b>1,090,444,168.05</b>	<b>118.9</b>
Үүнээс: орон нутгийн төсвөөс	м/төг	5,971,471,380.23	5,780,192,008.00	6,085,807,809.38	305,615,801.38	105.3
Хог тээвэрлэлтийн орлого				784,828,366.67	784,828,366.67	
<b>Нийт зардал</b>	м/төг	8,937,925,891.42	<b>5,870,192,008.00</b>	<b>9,333,535,014.75</b>	<b>3,463,343,006.75</b>	<b>159.0</b>
Үүнээс:						
а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг					
б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	8,937,925,891.42	5,870,192,008.00	9,333,535,014.75	3,463,343,006.75	159.0
в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг					
<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	м/төг	<b>(2,988,397,059.51)</b>	<b>-</b>	<b>(2,462,898,838.70)</b>	<b>(2,462,898,838.70)</b>	<b>-</b>

ХТ05430 65:5022859

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Компани, түүний үйл ажиллагаа**

“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ нь Дархан сумын нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийх, гудамж талбайн гэрэл гэрэлтүүлгийн эвдрэл гэмтлийг засварлах, ногоон байгууламжийн арчилгааг хариуцах гэсэн чиглэлээр үндсэн үйл ажиллагаа явуулдаг байна.

#### **3.2 Компанийн гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай багц хуулиудын мөрдөж ажилладаг байна.

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Тус байгууллагын дарга зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол дотоод хяналтын нэгж санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянадаг байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,054,734.4 мянган төгрөгөөр буюу 32.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,778.0	822,556.0	818,778.0
Авлага	-	-	-
Бараа материал	789,319.0	751,963.7	(37,355.3)
Үндсэн хөрөнгө	23,701,440.2	30,974,751.9	7,273,311.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>24,494,537.2</b>	<b>32,549,271.6</b>	<b>8,054,734.4</b>
Өр төлбөр	177,198.9	-	(177,198.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	24,317,338.3	32,549,271.6	8,231,933.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>24,494,537.2</b>	<b>32,549,271.6</b>	<b>8,054,734.4</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 822,556.0 мянган төгрөг болж өмнөх оноос 818,778.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 6,870,636.2 мянган төгрөгийн орлого олж, 9,333,535.0 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл 751,963.7 мянган төгрөг болж 37,355.3 мянган төгрөгөөр буурсан нь 1,357,951.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 1,129,007.0 мянган төгрөгийн материал зарцуулж, 174,766.6 мянган төгрөгийн материалыг “Дархан хотын тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-т шилжүүлж, байгууллагын даргын 2024 оны Б/154 тоот тушаалаар 91,532.6 мянган төгрөгийн материалыг акталсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 30,974,751.9 мянган төгрөг болж 7,273,311.6 мянган төгрөгөөр өссөн нь 162,767.5 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын 01-А/491 тоот захирамжаар 12,704,814.6 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1,096,686.60 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18 болон 28 дугаар тогтоолоор 4,089,717.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18 болон 28 дугаар тогтоолоор 420,332.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант онд 3,252,194.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Эздийн өмчийн дүн 32,549,271.6 мянган төгрөг болж 8,231,933.3 мянган төгрөгөөр өсөхөд тайлант үеийн 2,462,898.8 мянган төгрөгийн алдагдал, үнэ төлбөргүйгээр хүлээн авсан хөрөнгө голлон нөлөөлжээ.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу “Дархан хотын тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн

төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлант оны гүйцэтгэлээр 6,870,636.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 9,333,535.0 мянган төгрөгийн зардал гарган, 2,462,898.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогыг 5,780,192.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 6,870,636.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 1,090,444.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Тайлант онд 2,462,898.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь тухайн тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн хувь хүний орлогын албан татвартай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Ч.Цэрэннадмид, чанарын менежер Т.Эрдэнэтуяа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ийн 2024 оны санхүүгийн тайланг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 8,937,925.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 89,379.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 23,481.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 284.3 мянган төгрөгийн акт, 23,197.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	284.3	1	284.3	100.0
Зөвлөмж	2	23,197.2	2	23,197.2	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>23,481.5</b>	<b>3</b>	<b>23,481.5</b>	<b>100.0</b>

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 38,943,745.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тус “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ нь эхлэлтийн балансад эздийн өмчийн дүн байгаагүй бөгөөд тайланд онд өмчийг 38,943,745.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйл “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт” 211.7. “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргана” заалт, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, Оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул эздийн өмчийн бусад хэсгээр бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 320.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэн тул төсөвт буцаан төлүүлэхээр 320.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1 Илрүүлэлт:** Тайлант онд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс олгохдоо тус газрын даргын хавсран ажил гүйцэтгэх тушаал шийдвэргүйгээр мужаан О.Энхбаатарт 320.0 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад “*хариуцлагатай байх*”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтад “*Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтооно*” гэж заасантай нийцэхгүй тул төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

### 5.3 Зөвлөмж<sup>2</sup>

#### 5.3.1. Илрүүлэлт:

Тайлант онд хувь хүнд 9,940.0 мянган төгрөгийг хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “*Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө.*”, 28.7-д “*Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.*” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Өгсөн зөвлөмж:

Хууль журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус ОНӨААТҮГ нь эхлэлтийн балансд эздийн өмчийн дүн байгаагүй бөгөөд төрийн өмчийг 38,943,745.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.	1	38,943,745.0			1	38,943,745.0						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>38,943,745.0</b>			<b>1</b>	<b>38,943,745.0</b>			<b>1</b>	<b>38,943,745.0</b>		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс олгохдоо тус газрын даргын хавсран ажил гүйцэтгэх тушаал шийдвэргүй мужаан О.Энхбаатарт 320.0 мянган төгрөг илүү олгосон байна.	1	320.0	1	320.0						
Тайлант онд хувь хүнд 9,940.0 мянган төгрөгийг хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна.	1	9,940.0			1	9,940.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>10,260.0</b>	<b>1</b>	<b>320.0</b>	<b>1</b>	<b>9,940.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-				
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>